



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/58.

Хэрлэн сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 4 дүгээр багийн иргэн Л.Жанчивдоржийн эмчилгээний зардалд зориулан буцалтгүй тусламж үзүүлсүгэй.
2. Буцалтгүй тусламжид шаардагдах 150000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн тэтгэмж урамшууллын зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА